



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 07 сарын 01 өдөр

Дугаар 6/44

Бор-өндөр сум

**Ч.Мөнгөнчимэгийг Эмнэлзүй эрхэлсэн даргаар
хавсран ажиллуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1, 56.2, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Бор-Өндөр сумын Нэгдсэн эмнэлгийн хөдөлмөрийн дотоод журмын 4.4, Үйлдвэрчний эвлэлийн хорооны 2024 оны хамтын гэрээний 3.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эх барих, эмэгтэйчүүдийн эмч Ч.Мөнгөнчимэгийг 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн Эмнэлзүй эрхэлсэн даргаар хавсран ажиллуулсугай.
2. Ч.Мөнгөнчимэгт Эмнэлзүй эрхэлсэн даргын хавсран гүйцэтгэсний нэмэгдлийг цалингийн 30%-иар тооцож олгохыг Нягтлан бодогч (Т.Эрдэнэболор)-т зөвшөөрсүгэй.
3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хүний нөөцийн мэргэжилтэн (Б.Энхмаа)-д даалгасугай.

ДАРГА

А.БАТБААТАР

